

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Хүснэгт 2

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1.	Стратегийн болон Томоохон ордуудын эдийн засгийн үр өгөөж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагат ай	Үйл ажиллагааны зардлаар	Үнэн бодитой мэдээлэл хүргүүлсэн байна.	Мэдээллээр хангаж ажилласан.	Шаардлагат ай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлсэн байна.	1. Үйл ажиллагаа явуулж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын 2024 оны 10 уулын ажлын төлөвлөгөө, 2023 оны 9 тайланг хянан хүлээн авсан. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 8 төслийн техник, эдийн засгийн үндэслэл, түүний тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлээ. 2. Үндэсний Баялгийн сангийн тухай хуулийн төслийг УИХ-р хэлэлцүүлэх ажлын хүрээнд УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орсон Стратегийн ач холбогдол бүхий 16 орд, 2 дугаар хавсралтад орсон 39 ордын мэдээллийг бэлтгэж АҮЭБЯ-ны СХОГ-ын даргад 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хүргүүлсэн.	100%

1.1.1	мэдээллээр хангана.	Үйл ажиллагааны зардлаар	Үйл ажиллагаа явуулж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангана.	100%	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	1. Үйл ажиллагаа явуулж байгаа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын 2024 оны 10 уулын ажлын төлөвлөгөө, 2023 оны 9 тайланг хянан хүлээн авсан. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 8 төслийн техник, эдийн засгийн үндэслэл, түүний тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлээ. 2. Үндэсний Баялгийн сангийн тухай хуулийн төслийг УИХ-р хэлэлцүүлэх ажлын хүрээнд УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орсон Стратегийн ач холбогдол бүхий 16 орд, 2 дугаар хавсралтад орсон 39 ордын мэдээллийг бэлтгэж АҮЭБЯ-ны СХОГ-н даргад 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хүргүүлсэн. 3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдөр хүргүүлсэн. Хүрсэн түвшин: 100%	100%
1.1.2	Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд	Үйл ажиллагааны зардлаар	Салхитын мөнгөний орд, Зүүн цагаан дэлийн жоншны ордуудын 2 уулын ажлын	100%	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	1. Салхитын мөнгөний ордын 2024 оны уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан. Салхитын мөнгөний ордын 2023 оны уулын ажлын тайлантай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан. 2. Монголросцветмет ТӨҮГ-ийн MV-011722 тусгай зөвшөөрөлтэй Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн 2022 оны уулын ажлын тайлан, 2023 оны уулын ажлын	100%

шаардлагат ай мэдээллээр хангана.	төлөвлөгөө, 2 тайланг хянан баталгаажуулсан байна.	Газрын тосны олборлолтын тоо хэмжээ	4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн	4.8 сая баррель буюу 659.2 мянган тонн	төлөвлөгөө, тайлан, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч албажуулж ажилласан. Хүрсэн түвшин: 100%	80%
1.2. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх	Газрын тосны олборлолтын тоо хэмжээ	Үйл ажиллагааны зардлаар	4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн	4.8 сая баррель буюу 659.2 мянган тонн	2024 онд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайнуудаас 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн газрын тос олборлох төлөвлөгөөтэй байгаагаас хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн газрын тос олборлож, төлөвлөгөөний биелэлт 85.0 хувь байхаар байна. Газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2024 онд Тамсаг XXI талбайд хэвтээ 5 цооног өрөмдөж шингэн хагалбар перфораци хийх, 5 босоо цооног өрөмдөх, 10 хуучин цооног шингэн хагалбар, Тосон Уул XIX талбайд цооногийн мөргөцгийн хажуу өрөмдлөг 5 цооног, хуучин 5 цооног том хэмжээний шингэн хагалбар хийх, 1997 оны БХГ-т талбайд 5 цооног шинээр өрөмдөж перфораци, шингэн хагалбар хийх, 10 хуучин цооног сэргээн ашиглалтад оруулах ажлын төсөв, төлөвлөгөө батлагдсан. Матад XX талбайг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 256 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Матад сумын засаг даргын А/76 тоот тушаалаар Матад суманд газар ашиглах захирамж олгосноор Дорнод аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт ажил гүйцэтгэх А Даалгаврын хүсэлтийг 2024 оны 6 дугаар сарын 3-ны өдөр цахимаар хүргүүлснээр олборлолтын үйл ажиллагааг явуулах нөхцөл бүрдэж 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Цэнтогоруу цооногийн олборлолтыг эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар хонот 200 орчим баррель газрын тос олборлон, экспортлож байна. Тус онд газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Тосон-Уул XIX талбайд 5 цооног, Тамсаг XXI талбайд 7 цооног, БХГ-97 талбайд 2 цооног тус тус шинээр өрөмдсөн болно.	

<p>1.2. Олборлож буй тосны тоо хэмжээнд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>Олборлолтын тоо хэмжээн</p>	<p>4.7 сая баррель буюу мянган тонн</p>	<p>Эхний хагас жилд: 1.82 сая баррель буюу 247.3 мянган тонн Жилийн эцэст: 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн</p>	<p>Газрын тосны олборлолтын үйл ажиллагааг эсэргүүцэн талбай дээр жагсаал цуглаан зохион байгуулсан этгээдүүдийн хувьд Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газруудад дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлж, мөрдөн байцаах үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томиллолтын удирдамжийн дагуу 2024 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 328 хоног ажилласан. Томиллолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас олборлож буй газрын тосны тоо хэмжээнд өдөр бүр хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Петроочайна дачин тамсаг ХХК нь Тосон-Уул XIX талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 486 цооног байгаа бөгөөд үүнээс нэгдсэн байгууламжид холбогдсон 400 цооног, холбогдоогүй 86 цооногоор хоногт дунджаар 4574 баррель, задгайгаар буюу цооног шавхалтад ашиглаж буй 364 цооног байгаагаас 72 цооногоор хоногт дунджаар 547 баррель, нийт 5121 баррель газрын тосыг хоногт олборлож байна. Тамсаг ХХI талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 307 цооногос 1,819,464 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 189,089 баррель, нийт 2,008,553 баррель буюу 270,399 тонн газрын тос олборлосон байна. Доншен Газрын тос (Монгол) ХХК нь БХГ-т 1997 оны талбайгаас 2024 онд 424,637 баррель буюу 59,390.0 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан цооногуудаас 312,898 баррель буюу 43,762 тонн газрын тос олборлосон. 1997 оны БХГ-т талбайд олборлолтын</p>
--	---------------------------------	--------------------------------	---	--	--

			<p>Тоног төхөөрөмж суурилуулсан нийт 188 цооног байгаа бөгөөд үүнээс дунджаар 138 цооногтоо хоногт дунджаар 1070 баррель олборлож байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр Монгол Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн тос олборлохоор байна.</p> <p>Хүрсэн түвшин: Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн</p>				
<p>1.2. Экспортолж буй тосны чанарын шинжилгээнд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны зөрдлаар</p>	<p>Экспортын тоо хэмжээ</p>	<p>4.6 сая баррель буюу 622.8 мянган тонн</p>	<p>Эхний хагас жилд: 1.82 сая баррель буюу 247.3 мянган тонн</p> <p>Жилийн эцэст: 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн</p>	<p>Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2024 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 143 хоног ажилласан. Томиллолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд тухай бүрд хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Тосон-Уул XIX талбайгаас 2024 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар нийт 762,155 баррель буюу 101,135 тонн газрын тосыг БНХАУ руу экспортоод байна. Өдөрт дунджаар 20 автоцистернээр 5,210 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.03 хувь, дундаж нягт 835.2 кг/м3 байна. Тамсаг XXI талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 3-ны байдлаар нийт 7,300 автоцистернээр 1,959,152 баррель буюу 270,582 тонн газрын тосыг БНХАУ руу экспортоод байна. Өдөрт дунджаар 20 автоцистернээр 5,545 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.05 хувь, дундаж нягт 865.4 кг/м3 байна. БХГ-97 талбайгаас 2024 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар 333,191 баррель буюу 49,652 тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон байна. Экспортолсон тосны усны агууламж 0.025 хувь, 15 градус дахь нягт 884.6 кг/м3 байсан. Мөн</p>	<p>70%</p>	

1.3.	Газрын тосны бүтээгдэхүүн ий хангамжийн тогтвортой байдлыг хангах, К-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Дотоодын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүн ий хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд өсөн нэмэгдэж буй хэрэглээтэй уялдуулан импортын хэмжээ, нийлүүлэлтийн үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх.	2023 онд 2.2 сая тонн	Эхний хагас жилд 1.2 сая тонн Сүүлийн хагас жилд 2.4 сая тонн	Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 2.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоод байгаа ба зорилтот түвшин болох 2.4 сая тоннд хүрсэн. Өсөн нэмэгдэж буй хэрэглээг тогтвортой ОХУ-ын нийлүүлэгч талуудтай хэлэлцэн, импортын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанитай тогтмол харилцаатай ажиллаж, манай улсад нийлүүлэхээр илгээсэн газрын тосны бүтээгдэхүүний ачилтын болон вагоны мэдээг хүлээн авч, сар бүрийн импорт, дараа сарын захиалгын хэмжээнд тухай бүр хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажилласны үр дүнд энэ онд дотоодын зах зээл дээр газрын тосны бүтээгдэхүүний хангамж тогтвортой байсан. Нийт импортолон газрын тосны бүтээгдэхүүний 2.3 тонн нь шатахуун бөгөөд үүнээс Евро-5 стандартын шатахуун 326.6 мянган тонн буюу нийт шатахууны 14 хувийг эзэлж байна. Манай гол ханган нийлүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхийн зах зээл дэх газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр 2024 онд К-5 /Евро-5/ стандартын шатахууны хувь хэмжээг зорилтот түвшинд хүргэж нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байсан болно. Тухайлбал, дайны нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ-ын дотоод зах зээл дээр К-5 /Евро-5/	экспортлож буй газрын тосны мэдээг өдөр бүр нэгтгэж 7 хоног бүрийн баасан гаригт ПГАХ-т цахимаар мэдээ хүргүүлж, шаардлагатай үед удирдлагатай утсаар холбогдож мэдээ, мэдээллээр хангаж, чиглэл авч ажилласан. Монгол Улсын хэмжээнд нийт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.09 сая баррель буюу 555.6 мянган тонн тос экспортлохоор байна. Хүрсэн түвшин: Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4.09 сая баррель буюу 555.6 мянган тонн	80%
------	--	---	-----------------------	---	---	---	-----

1.3.1	Дотоодын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд өсөн нэмэгдэж буй хэрэглээтэй уялдуулан импортын хэмжээ, нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх.	Үйл ажиллагааны зардлаар	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ, тонн	2.2 сая	Эхний хагас жилд: 1.2 сая Жилийн эцэст: 2.4 сая	- Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 2.6 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоод байгаа ба зорилтот түвшин болох 2.4 сая тонноос 200 мян.тн-оор илүү байна. Импортын хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл Аи-92 автобензин 25 хувь, дизель түлш 24 хувиар тус тус өссөн бол А-80 автобензин 73 хувиар буурсан байна. - Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар А-80 автобензин 18 хоног, Аи-92 автобензин 30 хоног, Аи-95 автобензин 53 хоног, дизель түлш 19 хоног, ТС-1 онгоцны түлш 15 хоногийн ердийн хэрэглээний үлдэгдэл, нөөцтэй байна. - Өсөн нэмэгдэж буй хэрэглээг тогтвортой хангах хүрээнд нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр манай гол ханган нийлүүлэгч ОХУ-ын нийлүүлэгч талуудтай хэлэлцэн, импортын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласны үр дүнд энэ онд дотоодын зах зээл дээр газрын тосны бүтээгдэхүүний хангамж тогтвортой байсан. ОХУ-ын Роснефть компанитай тогтмол харилцаатай ажиллаж, манай улсад нийлүүлэхээр илгээсэн газрын тосны бүтээгдэхүүний ачилтын болон вагоны мэдээг хүлээн авч, сар бүрийн импорт, дараа сарын захиалгын хэмжээнд тухай бүр хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажилласан.	100%
1.3.2	К-5 стандартын шатахууны импорт,	Үйл ажиллагааны зардлаар	Нийт шатахуунд эзлэх /Евро-5/	К5 стандартын шатахууны эзлэх хувь 14%.	Эхний хагас жилд: К5 /Евро-5/ стандартын	Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 2.3 сая тонн шатахуун импортлон, хэрэглэснээс Евро-5 стандартын шатахуун 326.6 мянган тонн буюу нийт шатахууны 14 хувийг эзэлж байна. Манай	70%

<p>хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх</p>		<p>ангиллын шатахууны эзлэх хувь.</p>	<p>шатахууны эзлэх хувь 50%. Жилийн эцэст: К5 /Евро-5/ стандартын шатахууны эзлэх хувь 50%.</p>	<p>гол ханган нийлүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхийн зах зээл дэх газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр 2024 онд К-5 /Евро-5/ стандартын шатахууны хувь хэмжээг зорилтот түвшинд хүргэж нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байсан болно. Тухайлбал, дайны нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ-ын дотоод зах зээл дээр К-5 /Евро-5/ стандартын шатахууны эрэлт нэмэгдэж, экспортын хязгаарлалт хийсэн, мөн БНХАУ-ын төмөр замаас Монгол улс руу шатахуун тээвэрлэх вагоны зөвшөөрөл энэ оны 3 дугаар сараас хойш олгоогүй зэрэг шалтгаанаар нийлүүлэгч талаас К-5 /Евро-5/ стандартын шатахууныг захиалгын дагуу нийлүүлээгүй болно. Хүрсэн түвшин: К5 /Евро-5/ стандартын шатахууны эзлэх хувь 14%.</p>
<p>1.3. Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>Төслийн барилга, угсралтын ажлын явц, хувь.</p>	<p>Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100</p>	<p>Төсөл хэрэгжүүлэгч компани 2020-2022 онуудад Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0га газар эзэмших зөвшөөрөл авч төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Мөн үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Төсөл хэрэгжүүлэгч "Трансгейт интернэшнл" ХХК-аас Ховд аймагт хэрэгжүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийн төсөл санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй холбоотойгоор үйлдвэрийн төсөл түр зогсонги байдалд ороод байгаа талаар 2023 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн А/38 дугаартай албан бичгийг манай байгууллагад ирүүлсэн. Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаар тогтоолоор Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан ба энэхүү хөтөлбөрт тус арга хэмжээ тусгагдаагүй болно.</p>

1.4.	Газрын тосны бүтээгдэхүүн Д чанарын хяналт тавина	Үйл ажиллагааны зардлаар	Хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн хүсэлтийн тоо	Хяналт шалгалтаар авсан автобензин, дизель түлшний 168 дээжид шинжилгээг хийж сорилтын тайланг захиалагчид хүргүүлсэн	Ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	Хүрсэн түвшин: 70 Хяналт шалгалтаар авсан Нийт 38 (Автобензин -11, Дизель түлш-27) дээжид шинжилгээг хийж сорилтын тайланг захиалагчид хүргүүлсэн.	100%
1.4.1	Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахуунд чанарын хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн хүсэлтийн хувь	Хяналт шалгалтаар авсан автобензин, дизель түлшний 168 дээжид шинжилгээг хийж сорилтын тайланг захиалагчид хүргүүлсэн	Эхний хагас жилд: 100 % Жилийн эцэст: 100 %	Монгол Улсын Засгийн Газрын 2023.10.18-ны өдрийн 385 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024.01.30-ны өдөр батлагдсан "Улаанбаатар хот дахь газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцуудаар борлуулагдаж буй шатахууны чанар болон нөөцийн үлдэгдлийг хянах ажлын төлөвлөгөө"-ний дагуу дээж авсан. Үүнд: 1. 2024.03.20-ны өдрөөс 2024.05.30-ны өдөр хүртэл үйл ажиллагаа явуулж буй 16 аж ахуйн нэгжийн агуулах -Автобензиний - 5 ширхэг дээж -Дизель түлшний - 16 ширхэг дээж, нийт 21 дээжид 3 удаагийн физик, химийн шинжилгээг гүйцэтгэж үр дүнг боловсруулан, 32 ширхэг сорилтын тайлан хэвлэж, лабораторийн эрхлэгчээр баталгаажуулан 2024.06.05-ны өдөр ГТБХ-ийн дарга Д. Даваабаярт хүлээлгэн өгсөн. 2. 2024.11.13-14-ний хооронд үйл ажиллагаа явуулж буй 10 аж ахуйн нэгжийн агуулах - Автобензиний - 6 ширхэг дээж -Дизель түлшний - 11 ширхэг дээж нийт 21 дээж хүлээн авч 5 удаагийн физик, химийн шинжилгээг гүйцэтгэсэн. Хүрсэн түвшин: 100%	100%
3.1.	Ашигт малтмалын	Үйл ажиллагаа	Хайгуулын ажлын үр	Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Эрдэс баялгийн мэргэжлийн	2024 онд нийт Аж ахуй нэгж (ААН)-ээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 114 хайгуулын ажлын үр дүн, нөөцийн	95%

хайгуулын ажлын өгөөжийг дээшлүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөнө.	аны зардлаар	дүнгийн тайлан, нөөцийн тодотгол тайланг авч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.	зөвлөлийн хурлаар тайланг хэлэлцүүлсэн.	83	мэргэжлийн зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн тоогоор хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тодотгол тайланг хэлэлцүүлсэн байна.	Тодотгол тайланг хүлээн авч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн "Ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх" салбар хуралдааныг 12 удаа, ЭБМЗ-ийн "Ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх" Өргөтгөсөн хуралдааныг 1 удаа тус бүр зохион байгуулсан. Үүнээс Хэлэлцсэн тайлан 104, хүлээн авсан тайлан 89, шаардлага хангаагүй дахин хэлэлцэхээр буцаасан тайлан 15, тодорхой шалтгааны улмаас хэлэлцээгүй тайлан 10. ЭБМЗ-ийн салбар хуралдаан болон өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан тайлангийн дүгнэлт, тушаал шийдвэрийг гаргуулан дүгнэлт, тушаал, хуралдааны тэмдэглэл холбогдох материалыг УГА-ны баримтын төв архивд хүлээлгэн өгсөн. Нөөцийн бүртгэлийг хөтөлж, ажлын хэрэгцээний мэдээллийн сан үүсгэсэн.
3.1.1 Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн шаардлага хангасан ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн тодотгол тайланг хүлээн авч хянах, Эрдэс баялгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх. Шийдвэрлэсэн	Үйл ажиллагааны зардлаар	Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тодотгол тайланг ирүүлсэн хүсэлтийн тоогоор Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 100% хэлэлцүүлсэн байна.	83 тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.		Эхний хагас жилд: Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн тоогоор 100% хэлэлцүүлсэн байна. Жилийн эцэст: Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн тоогоор 100% хэлэлцүүлсэн байна.	2024 онд нийт Аж ахуй нэгж (ААН)-ээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 114 хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайланг хүлээн авч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн "Ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх" салбар хуралдааныг 12 удаа, ЭБМЗ-ийн "Ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх" Өргөтгөсөн хуралдааныг 1 удаа тус бүр зохион байгуулсан. Үүнээс хэлэлцсэн тайлан 104, хүлээн авсан тайлан 89, шаардлага хангаагүй дахин хэлэлцэхээр буцаасан тайлан 15, тодорхой шалтгааны улмаас хэлэлцээгүй тайлан 10. ЭБМЗ-ийн салбар хуралдаан болон өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан тайлангийн дүгнэлт, тушаал шийдвэрийг гаргуулан дүгнэлт, тушаал, хуралдааны тэмдэглэл холбогдох материалыг УГА-ны баримтын төв архивд хүлээлгэн өгсөн. Нөөцийн бүртгэлийг хөтөлж, ажлын хэрэгцээний мэдээллийн сан үүсгэсэн.

<p>тайлангаас нөөцийг ашигт малтмалын төрлөөр бүртгэн ажлын хэрэгцээний мэдээллийн санг хөтлөх</p>						90%
<p>3.1. Ашигт малтмалын хайгуулын ажлын жилийн тайланг цахимгаар хүлээн авах, төлөвлөгөөг хянах, шаардлага хангасан төлөвлөгөөг хүлээн авах, мэдээллийн нэгдсэн санг нэмэлт мэдээллээр баяжуулах</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>Цахим системд хуулийн хугацаанд ААН-ээс ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн тоогоор хянасан байна.</p>	<p>Эхний хагас жилд: Төлөвлөгөө 300, тайлан 150 хянасан байна. Жилийн эцэст: Төлөвлөгөө 700, тайлан 600 хянасан байна.</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заасны дагуу Ашигт малтмалын хайгуулын хэлтсийн хэмжээнд 2024 оны хайгуулын ажлын төлөвлөгөө нийт 1270 ирснээс 1261 төлөвлөгөө хянасан байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заасны дагуу Ашигт малтмалын хайгуулын хэлтсийн хэмжээнд 2023 оны тайлан нийт 1048 ирснээс 1048 тайлан хянасан байна. Хүрсэн түвшин: Төлөвлөгөө 1261, тайлан 1048 хянасан.</p>		90%
<p>3.2. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, Эрдэс Баялгийн нөөцийг</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>2023 онд Монгол Улсын хилээр дээж нэвтрүүлэх тодорхойлолтыг ААН-үүдийн</p>	<p>Монгол Улсын хилээр дээж нэвтрүүлэх тодорхойлолтыг ААН-үүдийн ирүүлсэн</p>	<p>1. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7-д заасны дагуу аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч, бүртгэх шийдвэрлэх гэж заасны дагуу албан бичгээр 3 тойм судалгаа хийх хүсэлт ирснийг хүлээн авч бүртгэж, 3 шийдвэрийн хариуг албан бичгээр хүргүүлж ажилласан. Үүнд: 1. Херуга эксплорэйшн ХХК-аас ирүүлсэн тойм судалгааны хүсэлт 2. Майнэксмайн ХХК-аас ирүүлсэн тойм судалгааны</p>		100%

	нэмэгдүүлэнэ	Үйл ажиллагааны зардлаар	Ирүүлсэн тоогоор олгосон байна.	8 хүсэлт шийдвэрлэсэн.	хүсэлтийн тоогоор олгоно.	хүсэлт 3. Говь вентур ХХК-аас ирүүлсэн тойм судалгаан хүсэлт Тайлбар: Тойм судалгааны ажил хийгдсэнээр геологийн ерөнхий анхдагч мэдээллийг бүрдүүлж тусгай зөвшөөрөл олголт нэмэгдэх мөн хөрөнгө оруулалтыг татах юм. 2.Хайгуулын талбайд тухайн үе шатны ажлыг гүйцэтгэсэн, хайгуулын ажлын зардлын доод хэмжээнээс багагүй ажил гүйцэтгэсэн талаарх баримт хүссэн 517 хүсэлтийн дагуу КХ, ТЕГ, Шүүх байгууллагуудад 517 тодорхойлолтыг тус тус хүргүүлж ажилласан байна.
3.2. 1	Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх замаар ашигт малтмалын хайгуулын ажилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Тойм судалгаа хийхээр ирүүлсэн хүсэлтийн тоогоор 100% шийдвэрлэсэн байна.	Эхний хагас жилд: Ирүүлсэн хүсэлтийн тоогоор 100% шийдвэрлэсэн байна. Жилийн эцэст: Ирүүлсэн хүсэлтийн тоогоор 100% шийдвэрлэсэн байна.	100%	Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7-д заасны дагуу аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч, бүртгэх шийдвэрлэх гэж заасны дагуу албан бичгээр 3 тойм судалгаа хийх хүсэлт ирснийг хүлээн авч бүртгэж, 3 шийдвэрийн хариуг албан бичгээр хүргүүлж ажилласан. Үүнд: 1. Херуга экспорзэйшн ХХК-аас ирүүлсэн тойм судалгааны хүсэлт 2. Майнэксмайн ХХК-аас ирүүлсэн тойм судалгааны хүсэлт 3. Говь вентур ХХК-аас ирүүлсэн тойм судалгаан хүсэлт. Хүрсэн түвшин: 3 тойм судалгаа хийх хүсэлт ирснийг хүлээн авч бүртгэж, 3 шийдвэрийн хариуг албан бичгээр хүргүүлж ажилласан.
3.3.	Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж ажиллана.	Үйл ажиллагааны зардлаар	Шардлагатай мэдээллээр тухай бүр хангах, нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө,	Төлөвлөгөөнд тусгуулсан.	100%	1. 2024 оны жилийн эцсийн байдлаар 194 тайлангаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 860.95 га талбайд 13.4 сая ширхэг мод тарьсан байна. 2. 2024 оны 366 төлөвлөгөөнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд 4,231.8 га талбайд 18.2 сая мод тарихаар тусгуулан ажиллалаа.

3.3.1	2023 оны тайлан болон 2024 оны төлөвлөгөөнд зөвшөөрөл эзэмшигчдийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусуулах, тухайн мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	тайланд тусгуулна. 1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. 2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд 1571.1 га талбайд 7.2 сая мод тарьсан байна.	100%	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	1. 2024 оны жилийн эцсийн байдлаар албажсан 194 тайлангаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 860.95 га талбайд 13.4 сая ширхэг мод тарьсан байна. 2. 2024 оны ашиглалтын үйл ажиллагааны албажсан 366 төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 937.0 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 969.6 га талбайд, дүүцүүлэх хамгаалах ажлыг 118,414.9 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд 4,231.8 га талбайд 18.2 сая мод тарихаар тусгуулан ажилласан. Хүрсэн түвшин: 1. 194 2. Тийм	90%
3.4.	Ашигт малтмалын тухай хууль болон уул уурхайн салбарын холбогдох бусад эрх зүйн актуудаар олгосон чиг	Үйл ажиллагааны зардлаар	Хууль, журмын хэрэгжилт хангагдсан байна.	Аж ахуй нэгжийн хүсэлтийг бүрэн хангаж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллана	Аж ахуй нэгжийн хүсэлтийг бүрэн хангаж, журмын хэрэгжилтийг хангаж, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллана.	2024 оны уулын ажлын 434 төлөвлөгөө, 2023 оны уулын ажлын 194 тайлантай танилцаж албажуулсан. 2023 оны уулын ажлын албажсан 194 тайлангаас уурхай, үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник, орон нутагтай хамтран ажиллах гэрээ болон гэрээ дүгнэсэн акт, ашиглалтын тусгай зөвшөөрлийн судалгааг хийж мэдээллийн санг баяжуулсан Ашигт малтмалын үнэ ханшийн мэдээллийг 12 удаа нэгтгэн гаргаж ХШУДАГ-т хүргүүлсэн. ЭБМЗ-ийн хурлаар батлагдсан ТЭЗҮ-ээс шинээр хэрэгжих төслүүдийн усан хангамж, эрчим хүч, тээвэр ложистик, газар зэрэг дэд бүтцийн талаарх	96%

	Үүргийг хэрэгжүүлнэ.				Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	<p>мэдээллийг нэгтгэн санг бүрдүүлж хөтлөн ажиллалаа. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордны тусгай зөвшөөрлийн талбайд ногдох улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи, хайгуулын ажлын зардлыг шилжүүлэн тооцож, тусгай зөвшөөрөл эзэмшигчид танилцуулан гэрээ байгуулах этгээдэд 8 гэрээ хүлээлгэн өгсөн. Хяналтын шатандаа 12 гэрээ явж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2,719,067,341.92 төгрөг улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар –Ашигт малтмал, газрын тосны газрын техник, эдийн засгийн үндэслэл хянах 168 тойрох хуудас нээснээс 158 нь бүрэн шийдвэрлэгдсэн. Газрын хэвлийн тухай хуулийн 32, 45 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны нөөцийн хөдөлгөөний бүртгэлд хяналт хийж УГА-нд хүргүүлсэн.</p> <p>• Ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа уулын ажлын тайлан ирүүлсэн 2022 оны 257, 2023 оны 194 уурхай, болон баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн мэдээллийг авч нэгтгэсэн ба техник, технологийн түвшний үнэлгээ хийхэд шаардагдах суурь мэдээллийг шинээр мэдээллийн санд хадгалав. • 2016-2023 онуудад, ашиглалтын үйл ажиллагаа явуулж уулын ажлын тайлан ирүүлсэн 1371 уурхайн олборлолтын болон баяжуулалтын тоног төхөөрөмжүүдийн мэдээллийг авч нэгтгэсэн ба техник, технологийн түвшний үнэлгээ хийж, шаардагдах суурь мэдээллийг шинээр мэдээллийн санд хадгалав. • Уул уурхайн эрдэс, түүхий эд, голлох ашигт малтмалын 2024-2027 он хүртэлх үнийн төсөөллийн талаар судалгааг хийж бэлтгэн, уул уурхайн салбарын тооцоо, төсөөлөл, шаардлагатай тоон мэдээллийг 2024.03.14-ний өдрийн 1/1147 дугаартай албан бичгээр УУХУЯ-нд хүргүүлсэн. • Нүүрсний уурхайнуудын олборлолт, экспортын мэдээ, ашигт малтмалын үнэ ханшийн мэдээллийг сар бүр нэгтгэн боловсруулсан. • Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дүгээр заалтын дагуу ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны 2023 оны албажсан 194 тайлангаас орон нутагтай хамтран ажиллах гэрээ болон</p>	100%
3.4.1	Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	1.Орон нутагтай хамтран ажиллах гэрээг бүртгэж 2023 оны 200 уулын ажлын тайланг хянан баталгаажуулна. 2.2024 оны үнэ ханшийг судалж, үйлдвэрлэлийн мэдээллийг 12 удаа, жишиг үнийн удаагийн мэдээллийг тус тус гаргасан. 4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн зардлын нөхөн төлбөрийн 4	1.2022 оны 175 уулын ажлын тайлангаар Орон нутагтай хамтран ажиллах гэрээг санд нэгтгэсэн 2.2023 оны үнэ ханшийг судалж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээллийг 12 удаа, жишиг үнийн удаагийн мэдээллийг тус тус гаргасан. 4.Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн зардлын нөхөн төлбөрийн 4	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%		

		<p>Уурхайн бүтээгдэхүүний 2024 оны 1-12 саруудад баримтлах экспортын жишиг үнийг тодорхойлох од 12 удаа оролцоно.</p> <p>4. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн зардлын нөхөн гэрээг байгуулна.</p>	<p>гэрээг байгуулсан.</p>	<p>Гэрээ дүгнэсэн актыг авч нэгтгэн мэдээллийн санг хөтлөлтөд хяналт тавин ажилласан. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын тусгай зөвшөөрлийн талбайд ногдох улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи, хайгуулын ажлын зардлыг шилжүүлэн тооцож, тусгай зөвшөөрөл эзэмшигчид танилцуулан гэрээ байгуулах этгээдэд 8 гэрээ хүлээлгэн өгсөн. Хяналтын шатандаа 12 гэрээ явж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2,719,067,341.92 төгрөг улсын төсөвт төвлөрүүлээд байна. Шинээр 2024 онд 61 ширхэг улсын төсвийн хөрөнгөөр хайгуулын ажил хийгдсэн тайлангийн давхцалтай эсэх талаар лавлагаа хүссэн хүсэлт ирүүлсний дагуу давхцалыг Үндэсний геологийн албаны Геологийн баримтын төв архиваас шүүлтгэх ажлыг зохион байгуулж хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3.Тийм</p>	<p>90%</p>
<p>3.4.2</p>	<p>2023 онд олборлолт явуулсан аж ахуйн нэгжүүдийн металл, бус ашигт малтмал болон нүүрс зэрэг ордуудын нөөцийн хөдөлгөөний тоо</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>2022 оны албажсан уулын ажлын тайлангийн нөөцийн хөдөлгөөнийг хийсэн.</p>	<p>Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%</p>	<p>Газрын хэвлийн тухай хуулийн 32, 45 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 254 уулын ажлын тайлангийн нөөцийн хөдөлгөөний бүртгэлд хяналт хийж УГА-нд хүргүүлсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 1.254 2.Тийм</p>

3.4.3	бүртгэлийг хөтлөх Уул уурхайн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн боловсруулсан орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Үйл ажиллагааны зардлаар	Ирүүлсэн 150 техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	100%	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	ЭБМЗ-ийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 24, өргөтгөсөн 4 нийт 28 хуралдаанаар 168 төслийг хэлэлцэж хүлээн авсан - 86 засвартай хүлээн авсан - 63 буцаасан-10 хойшлуулсан-8 боловсруулсан түвшинд танилцсан-1 тус тус байна. Нийт 159 техник, эдийн засгийн үндэслэлийн хурлын тэмдэглэл, 158 дүгнэлтийг боловсруулан баталгаажуулж аж ахуй нэгжид хүргүүлсэн. Хүрсэн түвшин: 1. Тийм 2. Тийм 3. 28 4. Тийм 5. Тийм	100%
3.4.4	Ашиглалтын үйл ажиллагааны зардлаар төлөвлөгөө, тайланг цахим системээр хүлээн авах, мэдээллийн	Үйл ажиллагааны зардлаар	420 уулын ажлын 2024 оны төлөвлөгөөг, 200 уулын ажлын 2023 оны тайланг хянан албажуулна.	2023 оны уулын ажлын 417 төлөвлөгөөг, 2022 оны 175 тайланг хянан албажуулсан.	Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100%	1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2024 оны 509 уулын ажлын төлөвлөгөөг цахим хэлбэрээр хүлээн авч танилцсан. Үүнээс: • Албажсан – 434 • Албажаагүй – 62 • Татгалзсан – 13 Мөн 2024 онд үйл ажиллагаа явуулахгүй тухай 745 Х төлөвлөгөө хүлээн авсан байна. 2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2023 оны 291 уулын ажлын тайланг хүлээн авч танилцсан. Үүнээс:	100%